**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.**

**2024.12.06.**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **Салбарын зорилго:** Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэдэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1.1. **Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.** | | | | | | |
| 1.1 | Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 500,0 | “Бүх нийтийн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | “Бүх нийтийн боловсрол” хөтөлбөрийн хэрэгжилт 90 | Бүх нийтийн боловсрол” хөтөлбөрийн хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүргэнэ. | “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2-р үе шат 2021-2023 онд хэрэгжиж дууссан. Хөтөлбөр 94 хувьтай хэрэгжсэн. Сургалтын зайн хэлбэрийг ашиглан “Хууль зүйн үндэсний хүрээлэн” цахим группээр тавигдаж байгаа мэдээ мэдээллийг “Нарийнтээл Хууль эрх зүйн хөтөч” фэйсбүүк группэд түгээн иргэдэд хэрэгцээтэй хуулиудыг сурталчлан таниулж, бусдад түгээх үйл ажиллагааг цахим технологид суурилсан арга хэлбэрээр олон нийтэд хүргэж байна. “Авлигын эсрэг хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, Уралдаанч хүүхдийн аюулгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлын талаар постер бэлтгэн цахимаар түгээж ажилласан. | |
| 1.2 | Эрх зүйн танхимын үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, хууль, тогтоомжийн лавлагаа олгох, бусад шаардлагатай хууль зүйн туслалцааны үйлчилгээг нэвтрүүлнэ. | - | "Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, үр дүнг тооцон ажиллах. | Шинээр гарсан эрх зүйн актуудаар цахим орчинд 18 удаа мэдээлэл оруулахад хандалтын тоо 830, мэдээлэл хуваалцсан 87 хүн байна. Хуулийн мэдээллийг иргэдэд өгсөнөөр урд оноос 50 хувиар нэмэгдүүлэн ажилласан | "Эрх зүйн сургалт сурталчилгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн төлөвлөгөө 100% хэрэгжсэн байна. | www.e-khutuch.mn- танд туслах цахим хөтөчөөс хуулийн талаар мэдээлэл авч өгөх, мөн өөрсдөө эрх зүйн хөтчийн буланг ашиглаж өөрт хэрэгтэй хуулийн заалтаа авч болох талаарх багийн Иргэдийн Нийтийн хурал дээр мэдээлэл өгч ажилласан. 2024-оны 12 дугээр сарын байдлаар 35 иргэн, 4 байгууллагат хуулийн зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Тамгын газарт эрх зүйн хөтчийн булан ажиллуулснаар иргэд хуулийн талаарх мэдээллийг цахимаас авах боломж бүрдсэн байна. 2021-2024 онуудад давхардсан тоогоор нийт 83 иргэнд хуулийн зөвлөгөө өгөхөөс гадна хуулийн дагуу гарсан журам заавруудаар зөвлөгөө өгч байна.. Эрх зүйн хөтчийн булангаас хуулийн мэдээллийг авч байгаа иргэдийн тоо нэмэгдэж өмнөх онуудаас 1,5 хувиар өссөн байна. Ард иргэд малчдад явуулын хэлбэрээр хуулийн зөвлөгөөг насан туршийн суралцахуйн нэгжийн багштай хамтран хөдөөгүүр явж 51 малчин өрхийн 127 малчинд цахимын хэрэглээний талаар болон бусад хуулийн талаар мэдээлэл өгч ажилласан | 100 |
| 1.3 | Монгол Улсын хууль, тогтоомж, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн сумын нэгдсэн санг шинэчлэн хийнэ. | - | -Хяналтад авсан шийдвэрүүдийн бүртгэл хяналтыг нэмэгдүүлсэн байдал | Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо өссөн дүнгээр | Сумын Засаг даргын захирамж, төсвийн байгууллагуудын ерөнхий менежерийн тушаал, шийдвэрүүдийн | Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудаар Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагууд цахим сан үүсгэн ажиллаж байна. Цахим санд бүртгэсэн эрх зүйн актуудыг мэдээнд тусган авч улирал болгон нэгтгэн гаргаж ажилладаг ба 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 13577 эрх зүйн акт бүртгэлтэй байна. Мөн эрх зүйн ажлын мэдээ тайланг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хагас жил тутам хяналт-шинжилгээ хийх. | 12737, хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан | эрх зүйн үндэслэлийг хангуулан, байгууллага бүр хууль тогтоомжийн мэдээллийн цахим сан, бүртгэлийг эрхлэн хөтөлж, баяжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж ажилласан байна. | аймгийн Хууль Зүйн хэлтэст хуулийн хугацаанд гарган өгч хэвшээд байна. 2021-2024 онуудад шинээр гарсан хууль 34, хуулийн нэмэлт өөрчлөлт 558, Улсын Их Хурлын тогтоол 143, Ерөнхийлөгчийн зарлиг 63, Засгийн газрын тогтоол 66, Хүчингүй болсон эрх зүйн акт 42, цэцийн дүгнэлт 9, Олон улсын гэрээ 11-ийг тус тус цахимд санд нийт 926 эрх зүйн акт Засаг даргын Тамгын газрын хуулийн санд бүртгэлтэй байна. | |
| **Зорилт 1-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **100** |
| 2. | **Зорилт 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 2.1 | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 150,0 | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалтын тоо, бусад арга хэмжээ | “Авлигын эсрэг-Бидний оролцоо” сэдэвт сургалтыг 8-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 73 хүүхэд, мөн шторкны уралдаан зохион байгуулж 3 бичлэг ирснийг шалгаруулж, олон нийтэд | Авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх зорилгоор боловсролын байгууллагатай хамтран хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн банйа. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Авлигын эсрэг хууль”-иар сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 56 сурагч хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ нэмэгдүүлсэн. Ахлах ангийн сурагчдын дунд “АВЛИГЫГ ТЭВЧЬЕ, СЭРГИЙЛЬЕ” сэдэвт reel уралдааныг зохион байгуулсан. 6 бичлэг ирсэнээс эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшуулсан нийт 150.0 мян төгрөг зарцуулсан. 4-н жилийн өссөн дүнгээр 537 иргэн танхимын болон зайн сургалтад хамрагдаж хууль эрх зүйн мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сурталчилсан | | | |
| 2.2 | Төрийн байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | | -Иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан байдал<br>-Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар авлигыг үл тэвчих иргэд олон нийтийн дунд бий болгох чиглэлийн сургалтыг 3 удаа, зохион байгуулж 73 сурагч, 26 иргэнийг хамруулсан. | Соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байнIа. | Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ичинноров “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах” сэдвээр байгууллагын дарга, багийн дарга, нягтлан бодогч, татварын улсын байцаагч нарт сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 9 албан хаагч хамрагдсан.<br>“Хамтдаа авлигыг тэвчье, сэргийлье” аяны хүрээнд Өвөрхангай аймгийн насан туршийн суралцахуйн төвөөс видео бичлэг болон постер бэлтгэн цувралаар хүргэсэн. Уг постер, бичлэгийг сумын группээр болон “Нарийнтээл сум насан туршийн боловсролын нэгж” гэсэн группээр шэйрлэн иргэдэд түгээж ажилласан. Хандалтын тоо 465<br>Мөн багийн иргэдийн нийтийн хурлаар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар 45ш постер бэлтгэн иргэдэд тарааж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Бүх байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | | - Сумын төлөвлөгөөг батлуулж, төрийн байгууллагуудад хүргүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, үр тооцож дүгнэсэн байдал.<br><br>- Төлөвлөгөөний биелэлтийн хувь, мэдээ тайлангийн ирц | Төрийн байгууллагууд авлигаас ангид байх төлөвлөгөө гарган хэрэгжилтйг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. Засаг даргаас 8 төсвийн шууд захирагчийн гэрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалтыг тусган байгуулсан. | Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс доошгй хувь. | Төрийн байгууллага бүр Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, жил бүр үр дүнг тооцон ажилласан. 2024 оны 01 сард төрийн байгууллагуудын удирдлага, төрийн захиргааны албан хаагчидад ХАСХОМ, ХАСУМ гаргах , мэдэгдэл тайлбар гаргах түүнд анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулсан. Мэдэгдэл тайлбарын албан хаагч томилох, хяналт шалгалт хийх, ажлын хэсэг байгуулах, газар олгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулах зэрэгт тухай бүр гаргуулж хэвшсэн. 2024 оны онд нийт 38 мэдэгдэл тайлбар гаргуулж, АТГ-ын цахим системд бүртгэсэн.<br><br>2024 онд ХАСУМ хянуулах шаарлагатай 1 албан тушаалтны ХАСУМ-ыг тус тус АТГ-т хянуулж томилсон. Эдгээр албан хаагчдаар хуульд заасан 30 хоногийн дотор Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргуулсан. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ хугацаандаа гаргаагүй зөрчил гараагүй. | 100 |
| 2.4 | Төрийн байгууллагуудад дотоод хяналтын нэгж ажиллуулан, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ. | | - Дотоод хяналтын нэгж ажилладаг байгууллагын тоог бууруулахгүй байх. | Төрийн байгууллагуудын 89% нь буюу 8 байгууллага дотоод хяналтын нэгжтэй. | Нийт байгууллагын 90 хувийг дотоод хяналтын нэгжтэй болгож, үйл ажиллагааг нь | Байгууллагын даргын тушаалаар дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулан ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын ХШҮнэлгээний баг байгууллагуудын дотоод хяналтын нэгжид зөвлөн туслах явцдаа заавар зөвлөгөөг өгч, тухай бүр зөрчлийг нь арилгуулж ажилласан. Дотоод хяналтын нэгжийн тухайн жилд хийгдэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -2-оос доошгүй удаагийн арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан байх | | тогтмолжуулсан байна. | ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа байгууллагын эрсдлээ үнэлж төлөвлөсөн. 2024 онд дотоод хяналтын 6 ажил төлөвлөж эхний хагас жилд 6 ажлыг хийж гүйцэтгэн 100% биелэлттэй ажилласан. | |
| **Зорилт 2-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **100,0** |
| 3 | **Зорилт 3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.** | | | | | | |
| 3.1 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажлын хүрээнд сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн теле-камерын хяналтын системийн засвар үйлчилгээг хийх. | 1600,0 | Нийтийн хэв журмыг хамгаалах ажилд сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн теле-камерын хяналтын системийн засвар үйлчилгээг хийх. | Сумын хэмжээнд нийт 17 теле камертай. | Эвдрэл гэмтэлтэй теле-камеруудыг засварласан байна. | Энэ онд ОНХС-ийн хөрөнгөөр ЕБС-ийн заал гадна орчныг замержуулсан. Сумын төвд 7 камер, баруун гуанзанд 4 камер шинээр тавьсан. “Энд камер ажиллаж байна аюулгүй бүс” гэсэн анхааруулга тэмдэгийг 10 газарт байрлуулсан. Сумын төв, Баянтээг багийн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж ажиллав. Урьд онуудтай нийт 18 камер шинээр тавьж ажилласан байна. | 100 |
| 3.2 | Шатахуун түгээх станц, үйлчилгээний цэгийн теле камерыг сайжруулж, төв замын шаардлагатай хэсэгт анхааруулах хориглох тэмдэг шинээр байрлуулах ажлыг ААНБ-ын | 1000,0 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжсэн байна. | Суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ, ШТС-ууд бүгд камержсан, төв замын шаардлагатай хэсгүүдэд | Шатахуун түгээх станц, үйлчилгээний цэгийн теле камерыг сайжруулж, төв замын шаардлагатай хэсэгт | Шатахуун түгээх станц, үйлчилгээний цэг, тээврийн хэрэгслийн зогсоолын цэгүүдэд теле-камер, анхааруулах, хориглох тэмдэг шинээр байрлуулсан байна | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоотойгоор шийдвэрлэх. | | | анхааруулах хориглох тэмдэг дутмаг | анхааруулах хориглох тэмдэг шинээр байрлуулсан байна | | |
| 3.3 | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, хүүхдийг гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжэг зохион байгуулах | | Архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг буурч, хүүхэд гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй байна.. | Архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг буурсан, гэмт хэрэг зөрчилд хүүхэд холбогдоогүй | Архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг буурч, хүүхэд гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй байна. | Аймгийн ГХУСАЗСЗ –тэй хамтран сумын иргэд, албан байгууллагуудын ажилтан, албан хаагчдад “Одоо л больё” аяны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж 110 орчим иргэд, албан хаагчдыг хамрагдсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүүхдийн эрхийн тухай хуулиар, хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, стандартын хувцас хэрэглэлээр хангах, даатгалд хамруулах талаар гарын авлага бэлтгэн тус тус 200ш хэвлэн тараан олгосон. “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аянд сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчид нэгдэж, анги удирдсан багшаар дамжуулан “Дээрэлхэл түүний хор уршиг”, “Дээрэлхэлийн эсрэг бидний авах арга хэмжээ” зэрэг сэдвээр 1 цагийн мэдээлэл хийж 448 сурагч хамрагдсан. Аяны хүрээнд ангийн дарга нарын нөлөөлөл, манлайлалыг нэмэгдүүлэх зорилгоор “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяны бичвэртэй подволкоор хангаж ажиллаж байна. ЕБС-ийн 6, 7, 8-р ангийн 3 бүлгийн сурагчидтай “Өглөөний цай-Өглөөний уулзалт”-ыг хийж 65 хүүхэд хамрагдаж “Үе тэнгийн дээрэлхэлт”-ийн талаар санал бодлоо солилцож, сургуулийн орчинд үйлдэгдэх дээрэлхэлтийг таслан зогсооход | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурагчид болон багш, ажилчид, эцэг эхчүүд юу хийх талаар саналаа хуваалцаж, бие биенээ урмын үгээр шагнасан. Сумын 4-р багийн нутаг дэвсгэр болох Нарийн хэмээх газар 2024 оны 02 дугаар сарын 11-ны өглөө буюу шинийн 2-нд хурдан морины уралдаан нууцаар зохион байгуулагдаж 1 хүүхэд мориноос унасан зөрчил илэрсэн тул холбогдох байгууллагад мэдэгдэж, улмаар хүүхдийн улсын байцаагч ирж ажиллан уралдаан зохион байгуулсан 2 уяачийг зөрчлийн тухай хуулиар торгож, 1 уяачид хэрэг үүсгэн шалгаж байна. Өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахгүй байх Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд постер бэлтгэн сумын цахим групп тавьсан. Хандалтын тоо:375.<br><br>ЕБС-ийн 6-8 дугаар ангийн сурагчдад Хүүхэд хамгаалалын тухай хууль, Замын хөдөлгөөний байдлын аюулгүй тухай, Эрүүгийн хууль тухай, зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулж сургалтанд 101 сурагч хамрагдсан. Цагдаагийн байгууллагат гэр бүлийн хүчирхийллийн 4 дуудлага ирснээс 2-ын шийдвэрлэсэн ба 2 дуудлаганд ажиллаж байна. | |
| | Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын | 100,0 | - мал бүрийг бүртгэлжүүлсэн эсэх<br><br>- мал, махны гарал үүслийн гэрчилгээ | Малын гарал үүслийн гэрчилгээ 117-г цахимаар бичсэнийг | Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг урд оны түвшинээс бууруулна. | Сумын Бумбат суварга, Бумбат–Ур мал эмнэлэгүүд нь мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулж ажиллаж байна. Сумын ГХУСАЗСАлбар зөвлөлийн 2021 оны 11-р сарын 30-ны өдрийн 04 тоот тогтоолоор Малчдын Босго, Өшгөг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах. | | олголтыг цахимжуулах,<br><br>- малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах | баталгаажуулалт хийж ажилласан. | | Цахир, Харуул цохио 4 малчдын бүлэг байгуулж үйл ажиллагаа явуулж байна. Мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулж ажиллаж байна. “Бумбат суварга”, “Бумбат-Ур” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нийт 178 гэрчилгээг цахимаар бичсэнийг баталгаажуулалт хийж ажиллаж байна. Үүнд: Адуу 61, үхэр 20, хонь 171, ямаа 191, адууны мах 3900, хонины мах 1480 кг, ямааны мах 2456 кг, үхрийн мах 4459 кг, ноолуур 200, өөх 8000 кг тус тус бичигдсэн байна. Нийт мал 443 толгой, мах 12.2 тн бичигдсэн байна. | |
| 3.5 | Олон нийтийн болон цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас, тусгай хэрэгслийн хангалтад дэмжлэг үзүүлж ажиллана. | 34800,0 | Олон нийтийн цагдаагийн албан хаагчдын цалинг олгох, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас, тусгай хэрэгслээр хангах.<br>- Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг | Цалин хөлс, илүү цагийн нэмэгдэлд нийт 22,275,0 мян. төгрөгийн төсвийг зарцуулсан. Баянтээг ХК-ний нийгмийн хариуцлагын хүрээнд 4,0 сая.төгөөр цагдаагийн кобон байрны засварыг хийсэн. | Олон нийтийн болон цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас, тусгай хэрэгслийн хангалтад дэмжлэг үзүүлсэн байна. | 2024 онд цалин хөлс, илүү цагийн нэмэгдэлд нийт 19,139.0 мян. төгрөгийн төсвийг зарцуулсан. Сумын ГХУС зардлаас олон нийтийн 2 цагдаад ажлын тайланг үндэслэн сар бүр 200,0 мянган төгрөгийн урамшуулал тус бүр өгч ажиллаж байна. Мөн согтуурал хэмжигч багаж /тандагч/ , маяк, бусад хэрэгслээр хангаж ажиллав. | 100 |
| **Зорилт 3-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **94** |
| **Бүлгийн дундаж үнэлгээ** | | | | | | | **98,0** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2. Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх, Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| | **Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн зарим бүрэлдэхүүнтэй “Хээрийн дадлага” сургалтыг зохион байгуулах; | 200 0,0 | Томилгоот нэгжийн бүрэлдэхүүни й хувиар | 2023 онд сургалт болоогүй | сумын томилгоот бүрэлдэхүүний 10-15 хувийг хамруулна. | Аймгийн Цэргийн штабаас хуваарийн дагуу Сумын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг үндэслэн сумын батлан хамгаалах товчоо, цугларах, шилжүүлэх байрын бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага зохион байгуулдаг ба 2024 оны 3 дугаар улиралд орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй сургалт төлөвлөгдсөн боловч цаг үеийн ажлаас шалтгаалж хийгдээгүй. Сумын цэргийн дайчилгааны төлөвлөгөөний хөтлөгдөх баримт бичгийг шинэчлэн боловсруулсан. | 30 |
| **Зорилт 1-ийн дундаж** | | | | | | | **30** |
| 5 | **Зорилт 2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.** | | | | | | |
| 5.1. | Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулах | 300 0.0 | Дадлага сургууль зохион байгуулсан иргэдийн тоогоор | - | Дадлага сургууль зохион байгуулж, сумдын мэргэжлийн анги болон иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг олгосон байна. | 2024 оны 05 сарын 09-10-ны өдрүүдэд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг амжилттай зохион байгуулж 94.1% -тай үнэлэгдсэн.<br><br>СОК, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангиудын бүрэлдэхүүнд гал түймэр унтраах, малын гоц халдварт өвчин дээр дадлага сургуулилт хийсэн.Сумын Онцгой комисс мэргэжлийн ангийн дарга нарыг 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цагийн байдал дээр ажиллуулж дадлага сургуулилт дохион байгуулсан. | |
| **Зорилт 2-ийн дундаж** | | | | | | | **100** |
| **Бүлгийн дундаж үнэлгээ** | | | | | | | **65** |
| **Салбарын дундаж үнэлгээ** | | | | | | | **81,5** |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ** | | | | | | | |
| **Салбарын зорилго: Эдийн засгийн салбарт хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлэн эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.** | | | | | | | |
| **2.1.Санхүү, төсөв** | | | | | | | |
| 6 | **Зорилт 1. Төсвийн хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, төсвийн гүйцэтгэл , мэдээллийн ил тод байдлыг хангана.** | | | | | | |
| 6.1. | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих. | - | хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санд бүртгэлтэй албан хаагчийн тоо - Цалин хөлсний зардлын уялдаа | Төсвийн 8 байгууллагын 142 төрийн албан хаагчийн цалинг төрийн албаны цалингийн нэгдсэн системээр тооцон олгож хэрэгжүүлсэн. | Орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих. | Төсвийн 8 байгууллагын 152 төрийн албан хаагчийн цалинг төрийн албаны цалингийн нэгдсэн системээр тооцон олгож орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн цалингийн задаргаа байгууллагын ажилчдын албаны мэйл хаяг руу илгээгдэж ирдэг болсон. | 100 |
| 6.2. | Төрийн болон орон нутгийн өмчит ААН байгууллагуудын төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол | | - төсвийн 8 байгууллага, Төрийн сан, Баянтээг ХК, Баянтээг түлш зэрэг нийт 10 байгууллагын | 2023 онд Шилэн дансаны /www.shilendans.gov.mn/-д төсвийн 7 байгууллага, | Хагас бүтэн жилийн тайлан, 1-12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, | Төрийн 8 байгууллага тус бүр 126 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас Соёлын төв 1 мэдээ байршуулаагүй, Төрийн сан сар бүр 108 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас бүрэн байршуулсан, Баянтээг ХК сар бүр 116 мэдээлэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллах. | | шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавина. | Баянтээг ХК, , зэрэг нийт 8 байгууллагын 1884 мэдээлэлийг хуулийн хугацаанд байршуулахаас 1790 мэдээ байршуулж 95% | орон нутгийн орлогын мэдээ зэргийг сумын цахим хуудас болон шилэн данс бүрэн тавьсан байна. | шилэн дансанд байршуулахаас бүрэн байршуулсан байна. | |
| 6.3. | Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулах. | | - Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй иргэдийн тоо<br>- хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулсан иргэдийн тоо | Хугацааа хэтэрсэн зээлээс зээлийн үлдэгдэл 44,4% буурсан. | Сум хөгжүүлэх сангаас зээл аваад хугацаа нь дууссан болович төлөгдөөгүй, явцын хэтрэлттэй зээлүүдийг иргэд, аж ахуйн нэгжээр бүрэн төлүүлэх, тус сангийн хөрөнгийн ашигт байдлыг сайжруулах, эргэлтэд оруулах, | 2024 онд оны эхний зээлийн үлдэгдэл 233643.5 мян/төг байсан ба зээлийн үлдэгдэл 76246.5 мян/төг –өөр буурсан. 2024 онд хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгоогүй.<br><br>2022 онд 3 зээлдэгчийн нийт 8,072.5 мян.төгийн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн 6,584.3 мян төг-ийг барагдуулсан байна.<br><br>2024 онд 2 зээлдэгчийн нийт 6,839.4 мян.төгийн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн 4,409.4 мян төг-ийг барагдуулсан байна. | 70 |
| 6.4. | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх, эзэнжүүлэх, үр ашгийг тооцон, бүртгэлээр хяналт тавих. | | 2023 онд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр | 2023 онд ИТХ 5,204.7 мян/төг, ЭМТ 139,869.0мян/төг, сумын СӨББ 650,000.0 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх, эзэнжүүлэх, үр ашгийг тооцон, | 2024 оны хагас жилийн байдлаар Баянтээг ЕБС 5,337.0 мян/төг, ИТХ 18,500.0 мян/төг, ЗДТГ 10,605.0 мян/төг, Соёлын төв 20,866.0 мян/төг, ЭМТөв 16,816.7 мян/төг, СӨББ 1,489.0 мян/төг, ЕБС 6,632.7 мян/төгийн хөрөнгийг орлогот авч бүртгэлд оруулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мян/төг, ЕБС 321,396.3 мян/төг, ЗДТГ 233,353.3 мян/төг-ийн нийт 1,349,823.3 мян/төг хөрөнгийг орлогот авч бүртгэлд оруулсан байна. | бүртгэлээр хяналт тавьж ажилласан байна. | | |
| 6.5. | Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, Худалдан авах үйл ажиллагааны тендер шалгаруулалтыг цахимаар явуулна. | | - Тендерт шалгарсан сумын ААНБ-ын тоо<br>- Орон нутгийн үйлдвэрлэгчдээс нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо<br>- Худалдан авах үйл ажиллагааны тендер шалгаруулалтыг 100% цахимаар явуулна. | Сумын төсөвт байгууллагуудын хоол, хүнсний хэрэгцээт мах, сүү, төмс, хүнсний ногоо, болон бусад материалыг орон нутагт үйлдвэрлэн нийлүүлэлт хийсэн. | Худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, тендер шалгаруулалтыг 100 цахимаар явуулсан байна. | 2024 онд суманд зарлагдсан 25 төсөл арга хэмжээний 5 ажлыг суманд үйл ажиллагаа явуулдаг иргэд болон сумын ААН-үүд гүйцэтгэгчээр шалгарсан, мөн 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг ААН, 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Улаанбаатар хотын ААН тус тус шалгарч ажлыг 100% гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.6. | Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ. | | Гэрээт ажлын гүйцэтгэл чанар сайжирсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 10 ажилд сумын Засаг даргын захирамжаар иргэний төлөөлөл орцуулсан 5 хүний бүрэлдхүүнтэй хяналтын ажлын хэсэг ажилласан. | Худалдлан авах ажилллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, тухайн ажлыг хийж байгаа хугацаанд нь ИТХ, ЗДТГ-аас хууль журмын дагуу хяналтын ажлын хэсэг байгуулан тогтмол хяналт тавин ажилласан байна. | 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 22 ажилд сумын Засаг даргын захирамжаар иргэний төлөөлөл орцуулсан 5 хүний бүрэлдхүүнтэй хяналтын ажлын хэсэг ажилласан. Мөн ИТХ-ийн хяналтын ажлын хэсэг ажилд хяналт тавин ажилласан. | 100 |
| 6.7. | Төсвийн тухай хуулийн хүрээнд сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулах чиглэлийг боловсруулж, журам дагуу зарцуулж ажиллах. | | - Сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулсан эсэх.<br>- Тодорхой үр дүнд хүрсэн эсэх. | Орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулж ажилласан | Сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. | 2024 онд Эрсдэлээс хамгаалах сан 2024 онд 10,600.0 мян/төг-ийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд / мод тарих шатахуун, байгаль хамгаалах шатахуун, мал хамгаалах, бусад/ 34,756,6 мян/төг зарцуулсан.<br><br>Хоршоо хөшжүүлэх сан нь эхний зээлийн үлдэгдэл 233643.5 мян/төг байсан ба зээлийн эргэн төлөлт 76246.5 мян/төг орсон. 2024 хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгоогүй.<br><br>Орон нутгийн хөгжлийн сан нийт 25 төсөл арга хэмжээнд нийт 822,214.1 мян.төг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс 11 ажил 100% гүйцэтгэлтэй, 2 ажил 81% гүйцэтгэлтэй, 5 ажил 30-60% гүйцэтгэлтэй харилцахын үлдэгдэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 228,701.5 мян/төг байна. Малын албан татвар нийт 303,441.2 мян.төг-ийн санхүүжилтээр 13 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 1 ажил 100% гүйцэтгэлтэй, 1 ажил 60% гүйцэтгэлтэй хийгдэж байна. харилцахын үлдэгдэл 58,649.6 мян/төг байна. | |
| 6.8. | Төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан төсвийн шууд захирагч, төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод шуурхай механизмыг бий болгон хэрэгжүүлнэ. | | - Монгол Улсын 2023 оны төсөвтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийг тухай бүр мөрдөж ажилласан эсэх<br>- Төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.<br>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн, үнэн зөв, хугацаанд нь оруулах. | 1-12 сарын мэдээ, мэдээллийг цахим хуудас /www.shilendans.gov.mn/-т тухай бүр мэдээлж, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулаагүй, аймаг, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлж ажилласан. | 1. Монгол Улсын 2023 оны төсөвтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийг тухай бүр мөрдөж ажилласан байна.<br>2 Төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй ажилласан байна.. | Засгийн газрын 2021 оны 93 тогтоол “Орон нутаг болон тусгай зориулалтын шилжүүлэгийн санхүүгийн дэмжлэгийг бууруулан тооцох, 2022 оны 04 сарын 22-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль зэргийг мөрдөн ажиллаж байна. Төсвийг анхан шатны баримтанд тулгуурлан, тухайн батлагдсан төсөвт багтаан гүйлгээг хийж, хянан батлаж байна. Байгууллагууд 01-05 сарын байдлаар өр авлагын мэдээ өгөөгүй. Төсвийг зориулалт бусаар зарцуулаагүй хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулж байна. Мөн сар бүрийн 05-ны дотор багтаан төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагууд өгч хуулийн хугацаандаа мэдээгээ өгсөн төсөвт байгууллагын гүйлгээг хянан батлах зарчимаар ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9. | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ. | | - 2023 онд шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээгээр<br>- Балансад байгаа хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, тайланг ил тод байлгах. | Балансад бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг гэрчилгээжүүлэн, газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, бүртгэх, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан. | Төсөв ил тод нээлттэй, төсөв үр ашиггүй зарцуулагдахгүй алдагдлыг багасгаж, төсвийн сахилга хариуцлага сайжирсан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан байгууллага бүрт “өмч хамгаалах байнгын зөвлөл” , дотоод хяналтын баг төлөвлөгөөний дагуу өмч хөрөнгөд хяналт тавин бүрэн бүтэн байдлыг ханган, холбогдох албан хаагчидтай хамтран ажиллаж байна. 2024 онд хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд тооллогын комисс томилон, тооллогыг амжилттай хийж гүйцэтгэсэн.Төрийн өмч хөрөнгийг эзэмшигч иргэн болон төрийн албан хаагчтай хөрөнгө эзэмших бүрэн хариуцлагын гэрээ байгуулан ажилласан. | 100 |
| **Зорилт 1-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **97** |
| 7. | **Зорилт 2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | |
| 7.1. | Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна. | 100,0 | Татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулах | 2023 онд 78 татвар төлөгчдөд татварын хууль тогтоомж болон татварын хуулийг хэрэгжүүлээ гүйгээс гарах эрсдэлийн талаар 3 | Татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулснаар татвар төлөгчдийн татвар төлөх сэтгэлгээ хандлагыг | Татварын хууль тогтоомж болон татварын хуулийг хэрэгжүүлэх, төлбөрийн баримт олголтын талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 89 татвар төлөгчийг сургалтад хамруулсан. 2024 оны байдлаар шинээр бүртгэгдсэн 11 татвар төлөгчдөд татварын хууль тогтоомж болон татварын хуулийг хэрэгжүүлээгүйгээс гарах эрсдэлийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Аж ахуй эрхлэгч болон хувь хүмүүст “Татварын хялбаршуулсан горим ашиглах, бүртгүүлэх хасагдах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удаагийн сургалт зохион байгуулсан. | өөрчилсөн байна. | журам"–ын талаар нэг удаагийн сургалт зохион байгуулж мэдээлэл өгсөн. | |
| 7.2 | Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэдийг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. | - | Суманд үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэдийг татварын албанд бүртгэлтэй болгох. Татварын бааз суурийг нэмэгдүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлэх | 2023 онд Нарийнтээл суманд бүртгэлтэй 6 ААН, 30 аж ахуй эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. | Суманд үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэдийг татварын албанд бүртгэлтэй болгон, татварын бааз суурийг нэмэгдүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. | 2024 онд суманд бүртгэлтэй 68 ААН, 24 аж ахуй эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж буй 34 ААН, 15 аж ахуй эрхлэгч байна. 2024 онд аж ахуй эрхлэгчийн орлогын төлөвлөгөө 89572,8 мян.төг төлөвлөснөөс 11 дугаар сарын байдлаар гүйцэтгэл 86964,9 мян.төг, биелэлтийн хувь 97 байна. | 100 |
| 7.3 | Сумын орон нутгийн төсөв төвлөрөх татварын төлөвлөгөөг сар бүр нэр төрөл бүрээр жигд хангаж биелүүлэх арга хэмжэ авч ажиллах | - | Татварын төлөвлөгөөг сар бүр нэр төрөл бүрээр жигд хангаж биелүүлэх | 2023 оны жилийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 446724,5 мян/төг гүйцэтгэл 696727,8 мян/төг биелэлтийн хувь 156%, Татварын бус орлогын төлөвлөгөө 60720,3 мян/төг гүйцэтгэл | Сумын орон нутгийн төсөв төвлөрөх татварын төлөвлөгөөг сар бүр нэр төрөл бүрээр жигд хангаж 100% биелүүлж татварын өр авлага үүсгэхгүй байх. | 2024 оны 11 сарын 30-ний өдрийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 918,070.5 мян.төг гүйцэтгэл 822,114.2 мян.төг, 90 хувиар биелэсэн. Татварын өр авлагыг барагдуулахын хууль тогтоомжийн дагуу шат дараалсан арга хэмжээг авч, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 69158,3 мян/төг 114%-иар тус тус давж биелэсэн. | | | |
| **Зорилт 2-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **100** |
| **Бүлгийн дундаж** | | | | | | | **98,5** |
| **2.2. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ** | | | | | | | |
| 8. | **Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлнэ** | | | | | | |
| 8.1. | Тээлийн улаан ямааны биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгаа хийж, үүлдэр, омог болгох ажлыг хийж гүйцэтгэнэ. | | | Эрдэмтэдийн зөвлөлийн хурлаар Нарийнтээлийн “Улаан ямааг” Омог болгох асуудлыг хэлэлцэж 100 хувийн саналаар дэмжигдсэн болно. | ХАА яамны ажлын хэсгээр хянуулж “Улаан ямааг” Омог болгох асуудлыг дуусгах. | Тээлийн улаан ямааны судалгаа шинжилгээний ажлыг нэгтгэн Тээлийн улаан ямааны омгийн тодорхойлолтыг бичиж МААЭШХүрээлэнгийн их эрдэмтэдийн хурлаар оруулж 100 хувийн саналаар дэмжигдэн ХХААЯ нд ямааны омгийн тодорхойлолтыг 2024 онд цөм сүргийн 2000 ямааг ангилж ялган тэмдэглэхээс хаварын ангилалтаар 1000 ямааг ангилж бүртгэл хөтөлж livestock.mofa.gov.mn бүртгэлийн сестэмд бүртгэсэн. Намарын ангилалтаар мөн 1000 ямаанд ангилалт хийж ээмэглэж бүртгэлжүүлсэн байна. Нарийнтээл суманд үржүүлж байгаа нутгийн шилмэл ямаан дээр ажиллах Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын А/381 тушаалаар батлагдсан хянан магдалгаа хийх ажлын хэсэгийн 6 хүн, Өвөрхангай аймгийн Засаг даргын А/847 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэгийн 4 хүн Нарийнтээл суманд 2024 оны 11 дүгээр сарын 04 нөөс 7 хоногийн хугацаанд ажиллаж Өндөрхөмөг багийн цөм сүргийн 14 малчин өрхөөр орж ямааг газар дээр биеийн ерөнхий | 100<br>-<br> |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжилт, амьдийн жинг үзэв. Мөн 6 ямааг сойлтийн өмнөх жин, сойсний дараах жин, гулуузны жин, тал гулуузны жин, мах, яс, булчихрай, өөхний жинг тус тусд нь үзэж нядалж нядалгийн гарц тодорхойлов. Мөн мах, цусны шинжилгээг авч шинжилхээр авч явав. 2021-2024 онд 6036 ямааг ээмэглэн бүртгэж ангилалтыг зохион байгуулсан 235 ямаанд шингэн үрээр зохиомол хээлтүүлэг хийж төллөлт 90 хувьтай байсан. Аймаг сумын төсөвт өртөгөөр Нийт 41,7 сая төгрөгийг Тээлийн улаан ямааны судалгаа, шинжилгээ, ангилалтанд зарцуулсан байна. | |
| 8.2 | Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх | | | 2023 онд Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт нийт 97.163,8 мян.төг зарцуулсан байна. | Бүрдсэн орлогын 70-аас багагүй хувийг бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, малын чанар сайжруулах, тэжээлийн нэмэгдүүлэх, мал эмнэлгийн арга хэмжээнд зарцуулсан байна. | 2024 онд Малын тоо толгойн албан татвар 105,0 сая төгрөгийг ОНХ сангийн дансанд орсон байна.<br>Мал аж ахуйн албан татвараас мал аж ахуйн салбарт худаг гаргах, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна. | **70** |
| **Зорилт 1-ийн дундаж үнэлгээ** | | | | | | | **85** |
| 9 | **Зорилт 2. Малын халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэж тайван байдлыг хадгалан, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж бүрдүүлнэ.** | | | | | | |
| 9.1 | Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, үйл ажиллагааг сайжруулах | АНТ | угаалга, тарилга, туулгалтад 90-ээс дээш хувийн | Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион | Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад 100% хамруулна. | Сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/27 тоот “ Мал амьтны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай” захирамжаар 3 ажлын хэсэг дархлаажуулалтын ажлыг зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэлтэй хийсэн байх | байгуулах тухай” сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/44 дугаар захирамж гарч, мал эмнэлгийн нэгдсэн системд 8 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдилан сэргийлэх вакцинжуулалтыг 75700 толгой мал хийхээр төлөвлөлт оруулж технологит хугацаанд вакцинжуулалтыг эхлүүлсэн. 2 дугаар улирлын байдлаар вакцинжуулалтыг 35382 толгой малд хийж гүйцэтгэл 60 хувьтай хийгдэж байна. | | байгуулж байна. Мал эмнэлгийн нэгдсэн системд 53 өрхийн 6000 хонь төлөвлөж өгснөөс 2,4-р багуудын 53 өрхийн 5970 хонь хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдэж байна. Мөн хамгаалалтын бүс тогтоохоор нэмж 10000 тун вакцин авч мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж өгснөөр 2-р багт 4000 төлөвлөж өгснөөс 3981 хонь хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдсэн. 4-р багт Баянхонгор аймгийн Өлзийт сумтай хил залгаа 4-р багийн 48 өрхийн 6000 төлөвлөж өгснөөс 5973 хонь хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдэж байна. Нийт 16000 хонь вакцинжуулалтанд хамруулахаас гүйцэтгэл нь 15924 хонь хамрагдаж 99 хувьтай хийгдсэн.<br>Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/62 тоот “ Мал амьтны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай” захирамжаар 2 ажлын хэсэг дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж байна. Мал эмнэлгийн нэгдсэн системд 179 өрхийн 28400 хонь төлөвлөж өгснөөс 1,2-р багуудын 96 өрхийн 18403 хонь, 3-р багийн 63 өрхийн 9950 хонь нийт 159 өрхийн 28254 хонь хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдсэн байна.<br>2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/56 тоот Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай захирамжийн дагуу дараах вакцинжуулалт хийгдэнэ. Үүнд: Бумбат суварга, Бумбат-Ур мал эмнэлгүүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/57 тоот “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай” захирамж гарч вакцинжуулалтын ажлыг зохион байгуулан ажилласан. МЭНС-2 453 өрхийн 8722 үхрийг төлөвлөж өгсөнөөс Бумбат суварга 234 өрхийн 3173 үхэр, Бумбат-Ур 192 өрхийн 5258 үхэр нийт 426 өрхийн 8431 үхэр | | арга хэмжээнд ДХХ-ын вакцинд 16598 мал, шөвөг ярын вакцинд 15775 ишиг, Цусан халдвартын вакцинд 1387 үхэр, ДХХ-Энтеробактериоз вакцинд 12326 хонь, Галзуугийн вакцинд 7931 бод, бог, Боомын вакцинд 13272 бод, бог, Дуут хавдартын вакцинд 399 үхэр, сахуугийн вакцин 100 унага нийт 67788 мал хамрагдаж гүйцэтгэл нь 98 хувьтай мал эмнэлгийн нэгдсэн системийн гүйцэтгэлд хяналт тавин баталгаажуулалт хийж ажиллав. Дархлаажуулалтанд мал эмнэлгийн байцаагчийн дүгнэлт, сумын Засаг даргын тоот, малчдын гарын үсэг зурсан жагсаалт, акт, тайланг Мал эмнэлгийн газарт хүлээлгэн өгч ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдаж гүйцэтгэл 96.6 хувь хийгдсэн хяналт тавьж баталгаажуулалт хийж ажиллав. | | | |
